

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн  
газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг  
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11.4 дэх заалт болон Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2009-2012 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрмийг нэгдүгээр, аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг гуравдугаар, шинээр зохион байгуулагдах Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн албаны бүтцийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай зөвшилцөн эрүүл мэндийн газрын бүтцийг батлуулж, Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн албыг байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, бүтцийн өөрчлөлтэй холбоотой шаардагдах нөөц хөрөнгийг 2012 оны төсөвт тусгахыг Санхүү хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Энхболд)-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2009 оны 74 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЛАМБАА

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 11 сарын 19 өдрийн  
405 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## **АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрх, үүрэг, эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, харъяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлгээ өгөхтэй холбогдсон үйл ажиллагаа, харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

### **Хоёр. Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл**

- 2.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн хувьд эрүүл мэндийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд шатны бусад байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах чиг үүрэгтэй ажиллана.
- 2.2. Үйл ажиллагаандаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдөнө.
- 2.3. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.
- 2.4. Харъяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулна.
- 2.5. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, сум, сум дунд, өрхийн эмнэлэг, багийн их, бага эмчийн салбар, байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх алба, амаржих газар, хүүхдийн клиник сувилал зэрэг харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.
- 2.6. Аймаг, дүүрэг, сум, сум дунд, өрхийн болон хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга, зүйн зөвлөгөө өгч ажиллана.

- 2.7. Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүгийн удирдлагаар хангаж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.
- 2.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн болон эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.
- 2.9. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гарган холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, үйл ажиллагаатай нь холбоотой эргэх мэдээллээр хангана.
- 2.10. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашины ашиглалт, засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна.
- 2.11. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлогыг тодорхойлох, түншлэл болон хамтын ажиллагааг дэмжих замаар улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой харилцааг бий болгоно.
- 2.12. Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стратеги, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулах зарчмыг баримтална.
- 2.13. Эрүүл мэндийн асуудлаар салбар дундын зохицуулалтыг хангаж, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, олон нийтийг идэвхтэй оролцуулан хамтарч ажиллана.

### **Гүрээ. Удирдлага, зохион байгуулалт**

- 3.1. Орон нутгийн хүн амд эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн /ТБУСТХ/ 12.2 заалтын дагуу 12.1-д заасан эрхээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлж болно.
- 3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхээ шилжүүлэн ажилласнаар дээрх хуулийн 18.3.2 заалтад заасны дагуу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар орон нутгийн бусад эрүүл мэндийн байгууллага (нэгдсэн эмнэлэг, халдварт өвчний тандалт сэргийлэлтийн алба, нийслэлийн тусгай мэргэжлийн төвүүд, клиник сувилал гэх мэт)-ын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.
- 3.3. Эрүүл мэндийн газар нь удирдлага, санхүү, аж ахуйн хувьд бие даан ажиллах ба “Эрүүл мэндийн газар” гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

- 3.4. Эрүүл мэндийн газар нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, санхүү, хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж, орон нутгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдад тайлагнана.
- 3.5. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тухайн орон нутгийн онцлогт тохируулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, үйл ажиллагааны чиглэл”-ийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр батална.

### **Дөрөв. Эрх, үүрэг**

#### 4.1. Эрүүл мэндийн газрын эрх:

- 4.1.1 Нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг хянан шалгах, зааварлах, мэргэжлийн зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих,
- 4.1.2 Эрүүл мэндийн байгууллагуудад гарсан шинэ бүтээл, дэвшилтэт технологид дүгнэлт гаргах, санал өгөх,
- 4.1.3 Эрүүл мэндийн байгууллагуудын тэргүүний ажилтнуудыг шагнаж урамшуулах, аймгийн болон төр засгийн дээд байгууллагын шагналд тодорхойлох,
- 4.1.4 Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх,
- 4.1.5 Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн байдлыг хянах, тайлагнах,
- 4.1.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг судлан, шийдвэрлэх боломжит шийдлүүдийг зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,
- 4.1.7 Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах
- 4.1.8 Хуулиар олгогдсон бусад эрх


#### 4.2. Эрүүл мэндийн газрын үүрэг:

- 4.2.1 Энэ дүрмийн 3.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн засаг дарга эрхээ шилжүүлсэн тохиолдолд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг засаг даргын өмнө бүрэн хариуцах,
- 4.2.2 Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн


- захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх,
- 4.2.3 Өөрийн бүтцэд нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах,
- 4.2.4 Нутаг дэвсгэрийн хэмжээнд, орон нутаг дангаар болон хувийн хэвшилтэй хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг судалсаны үндсэн дээр тогтоож, түншлэх үйл ажиллагааны мэдээллийг гаргах,
- 4.2.5 Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагыг мэргэжил, арга зүйгээр хангах,
- 4.2.6 Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг аж ахуйн нэгж байгууллага, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах,
- 4.2.7 Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах талаар төрийн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, эх хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулах,
- 4.2.8 Нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион явуулах, өвчин үүсгэж буй халгаат хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх,
- 4.2.9 Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж, зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг илрүүлэн эмчлэх шат дараатай арга хэмжээг удирдан зохион байгуулах,
- 4.2.10 Хүний эрх, жендерын тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх,
- 4.2.11 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд үйлчлүүлэгч, иргэний нийгэм болон бусад хамтрагч талуудын оролцоог хангаж ажиллах,
- 4.2.12 Эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээг нэгтгэн зохион байгуулах, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулах, харъяа эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах, мэргэжлийн удирдлагаар хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх,
- 4.2.13 Нийтийн биеийн тамирын талаар төрөөс баримталж буй зорилго чиглэлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- 4.2.14 Хүн амыг биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, сэргээн засах болон эрүүл хоололтыг хөхүүлэн дэмжих, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх чиглэлээр дараах нэгжийг байгуулан ажиллуулж болно. Үүнд: Чийрэгжүүлэлтийн, Хоол зүйн, Хүчирхийлэлээс сэргийлэх-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх болон Өсвөр үеийн эрүүл мэндийн зэрэг нэгжүүд,

- 4.2.15 Эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж, төлөвлөлт хийх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах,
- 4.2.16 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх,
- 4.2.17 Тухайн орон нутагт дахь хүрээлэн байгаа орчны бохирдол, эрсдэлт хүчин зүйлийг тооцох, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нотолгоонд тулгуурлан үнэлэх чадвар бүхий орчны эрүүл мэндийн лаборатор байгуулан ажиллуулах,
- 4.2.18 Өөрийн харъяанд “Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн алба”-ыг байгуулан ажиллуулах,
- 4.2.19 Харъяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,
- 4.2.20 Хууль, тогтоомж, тушаал шийдвэрээр заагдсан бусад үүрэг

### Аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл



**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
үйл ажиллагааны чиглэл**





Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн алба

